



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/246

Сүхбаатар сум

Захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд "Аймгийн Засаг даргын 2020 оны А/220 тоот захирамжийн 1 дэх заалтын "8 дугаар сарын 31-ний" өдрийг дуустал гэснийг өөрчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг "2020 оны 9 дүгээр сарын 15-ны" өдрийг дуустал сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн "Аймгийн Засаг даргын 2020 оны А/212 дугаар захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулж, хугацаа сунгах, зарим газрын үйл ажиллагааг нээх тухай" А/220 дугаар захирамжийн 2 дах хэсэгт "...караоке,..." гэж нэмсүгэй.

3. Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээний газруудыг өглөөний 10:00 цагаас оройн 22:00 цаг хүртэл, хүүхдийн тоглоомын газар, биллиард, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын цагийн хуваарийг өглөөний 10:00 цагаас оройн 20:00 цаг байхаар тус тус тогтоож халдвар хамгааллын дэглэмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу чанд мөрдүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Энхбаатар/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx